

АРВАЙХЭЭР СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

2019.12.11

Арвайхээр сум

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Биелэлт
1	2	3	4
НЭГ. Нийгмийн бодлого зохицуулалт			
<i>1.1 Эрүүл мэндийн үйлчилгээ: Нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн, иргэдэд ээлтэй, тэгш, чанартай тусламж үйлчилгээг хүргэх замаар хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн дундаж наслалтыг уртасгана.</i>			
1.	АЗДҮАХ-ийн 3.1.5.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.1.7 дахь зорилт	Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Эрүүл мэндийн яамны 5 тэрбум 19 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгыг барьж барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90 хувьтай, ондоо багтаж ашиглалтад орно. 2020 онд Уламжлалт нөхөн сэргээлтийн шинэ эмнэлэг барьж, ашиглалалтад оруулахаар улсын төсөвт тусгагдсан. Үр дүнтэй 100 хувь
2.	АЗДҮАХ-ийн 3.1.2.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.1.4 дэх зорилт	Хүн амын дунд сүрьеэ өвчнийг илрүүлж, төгс эмчлэх замаар халдварын тархалтыг хязгаарлах	3 дугаар сард өрхийн эрүүл мэндийн төвүүд Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Сүрьеэгийн тасагтай хамтран эрсдэлт бүлгийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Үүнд: Уян сэтгэл 281 иргэнээс 270 буюу 96.4 хувь, Түшигдөлгөөн 284 иргэнээс 206 буюу 72.5 хувь, Нарны дөш 287 иргэнээс 206 буюу 90.5 хувь сумын дүнгээр 852 иргэн хамрагдахаас 736 буюу 86.3 хувьтай хамрагдлаа. Тус хамрагдсан иргэдээс сэжигтэй илэрсэн 76 иргэнийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дэлгэрэнгүй нарийн шинжилгээнд хамруулснаас 9 иргэнээс сүрьеэ илэрснийг өрхийн эрүүл мэндийн төв болон Сүрьеэгийн тасгийн хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг иргэн тус бүрээр үе шаттай хийж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт Сүрьеэгийн тасгаас “Сүрьеэ өвчний эмчилгээ, оношлогоо” сэдвээр дотоод сургалт зохион байгуулав. Мөн сүрьеэгийн идэвхигүй хэлбэрийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хүн амын дунд тогтмол асуумж, судалгаагаар хийж хэвшсэн. Үр дүнтэй 100 хувь

3.	<p>АЗДҮАХ-ийн 3.1.2.2 дахь Зорилт СЗДҮАХ-ийн 1.1.4 дэх зорилт</p>	<p>Хелико бактерийн тархалтын үзлэг шинжилгээнд хамрагдах замаар эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2019 онд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дүнгээр давхардсан тоогоор үйлчлүүлсэн 68486 иргэний 40 хувь нь хоол боловсруулах замын өвчлөлттэй бөгөөд эдгээр иргэдээс асуумж, илэрхий шинж тэмдгээр сэжигтэй иргэдийг тодруулж, хелико бактерийн оношлуурын түргэвчилсэн тестээр сэжигтэй буюу эрсдэлт бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төв 126 иргэнд хийснээс 71 иргэн буюу 56.3 хувь, Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төв 224 иргэнд хийснээс 64 иргэн буюу 28.5 хувь нь хелико бактертай оношлогдсон. Тус оношлогдсон иргэдийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвтэй хамтран эмчлэн эрүүлжүүлж байна.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
4.	<p>АЗДҮАХ-ийн 3.1.2.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.1.4 дэх зорилт</p>	<p>Хүн амын дунд БЗДХалдварт өвчнийг илрүүлж, төгс эмчлэх замаар халдварын тархалтыг хязгаарлах</p>	<p>2019оны 11 сарын дүнгээр нийт 380 халдварт өвчин бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 32.7 хувиар буурлаа. Халдвартөвчний тандалт судалгааг тухай бүр хийж, урьдчилан сэргийлэх, дэгдэлтийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг өрхийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгүүд жил бүр боловсруулан хэрэгжүүлж байна. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид улирал бүр ариутгал халдваргүйтгэлийн ажлыг Цуврайн гол нөхөрлөл хийж гүйцэтгэж, хэвшсэн. 2019 оны 11 сарын дүнгээр төрийн болон хувийн хэвшлийн 130 аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 42 усан санд ариутгал хийж нийт хамрагдах газруудын 85 хувьд гүйцэтгэлээ. Жил бүрийн 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад биеэр хамрагдсан залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 100 хувь хамруулж, серлогийн шинжилгээг иргэн бүрт хийж тэмбүү өвчний илрүүлэлтийг сайжруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2019 оны дүнгээр цэрэг татлагад хамрагдсан 1284 иргэнээс серлогийн шинжилгээгээр 43 тэмбүүгийн өвчлөл илэрснийг багийн Засаг даргын ажлын алба, өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн ДОХ/БЗДХалдварт өвчний кабинеттай хамтран эмчлэн эрүүлжүүллээ. Сумын Засаг даргын Тамгын газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Багийн Засаг даргын ажлын албаны хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг 02 дугаар улиралд зохион</p>

			<p>байгуулж, тус үйл ажиллагаагаар цэргийн насны иргэдийн эрүүл мэндийг сайжруулах ажилд ахиц гаргах арга замыг тодорхойлж, үүрэг чиглэл өгөв. Жил бүр эрүүл мэндээр тэнцсэн залуучуудаас цэргийн албанд татагдсан залуучуудыг Бүсийн оношлогоо эмчилгээний төвд 8 төрлийн үзлэг шинжилгээнд 100 хувь хамруулсан.</p> <p>2019 онд “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” “Залуу нас-Гэрэлт ирээдүй” дэд төслийн хүрээнд бэлгийн замаар дамжих халдварын тархалтыг бууруулахад өсвөр үеийнхэн, залуучууд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхийг зорилго болгон дараах ажлуудыг хийж байна.</p> <p>Үүнд: Эрсдэлт бүлгүүдийг тодорхойлж гаргасан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 29 сургагч багш нарыг бэлтгэсэн Эмийн сангуудын антибиотикийн худалдаанд хяналт тавьж, нөлөөллийн уулзалт хийсэн Хувийн эмнэлгүүдийн БЗДХалдварт өвчлөлийн тоон мэдээллийг бүртгэж эхэлсэн Өрхийн эрүүл мэндийн төв, сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд нөхөн үржихүйн боловсролыг нийт 5000 гаруй иргэнд хүргэсэн Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг 20 гаруй мянган иргэнд хүргэсний 50 орчим хувь нь шууд хүртэгсэд Албан байгууллага, залуус “Би бэлгийн замын халдвараас өөрийгөө 100 хувь хамгаалж чадна” уриалгад нэгдүүлэх зэрэг ажлуудыг эхлүүллээ.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
5.	АЗДҮАХ-ийн 3.1.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 1.1.6 дахь зорилт	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг вакцин био бэлдмэлийн хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн багтаамжийг нэмэгдүүлэх, вакцин устгалын автоклав болон шаардлагатай засвар	Вакцин биобэлдмэлийн тоног төхөөрөмж нэн шаардлагатай сумдад хуваарилагдан шийдэгдсэн, Арвайхээр сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ирээгүй .

		үйлчилгээний зардлыг шийдвэрлүүлэх	Үнэлэх боломжгүй
6.	АЗДҮАХ-ийн дахь зорилт СЗДҮАХ-ийн 1.1.6 дахь зорилт	3.1.7.2 ӨЭМТөвүүдийг итгэмжлэлд оруулж эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах нөхцөлийг бүрдүүлэх	Уян сэтгэл, Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвүүд магадлан итгэмжлэлд хамрагдаж, тэнцсэн. Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төв тоног төхөөрөмжийн дутагдлаас шалтгаалж тэнцээгүй.2019 оны 05 дугаар сард Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газарт Арвайхээр сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, 160.726.500 төгрөгийн төсөл бичиж хүргүүлсэн, тоног төхөөрөмж нийлүүлэгдвэл үлдсэн ӨЭМТөв хамрагдаж магадлан итгэмжлэлээ авна. Үр дүнтэй 100 хувь
7.	АЗДҮАХ-ийн 3.1.8 дахь зорилт СЗДҮАХ-ийн 1.1.7 дахь зорилт	Эрсдэлт бүлэгт хамаарах жирэмсэн эмэгтэйд шаардлагатай зарим шинжилгээг хийх	11 сарын дүнгээр 742 эхийг жирэмсний эрт хяналтад авч, эрт хяналтын хувь 90 буюу урьд оны мөн үеэс 2 хувиар нэмэгдсэн. Нийт жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийн 334 буюу 45 хувь нь өртөмтгий бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүд байна. Тус жирэмсэн эмэгтэйчүүдийг 6 төрлийн нарийн шинжилгээнд хамруулан БОЭТөвтэй хамтран хянаж байна. Эхийн эндэгдэл гараагүй. Үр дүнтэй 100 хувь
8.	АЗДҮАХ-ийн 3.1.8 дахь зорилт СЗДҮАХ-ийн 1.1.9 дэх зорилт	6 болон 12 настай хүүхдүүдийн шүдний эрүүлжүүлэх урвалж, оношлуураар хангах	Сургуульд суралцаж байгаа 8704 хүүхэд, цэцэрлэгт хамрагдсан 2983 хүүхдийн 60 хувь нь шүдний өвчлөлтэй гарсны 46 хувь буюу 3225 хүүхдийн шүдийг сургууль, цэцэрлэгийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвүүд БОЭТөвийн шүдний кабинет, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдтэй хамтран эрүүлжүүлсэн. Үүний 35 хувийг Happydent, Цэлмэгдент шүдний эмнэлгүүд 1 шүдийг 60.000 төгрөгөөр тооцон нийт 1000 хүүхдийг эмчлэн эрүүлжүүллээ. Үр дүнтэй 100 хувь
9.	АЗДҮАХ-ийн 3.1.2 дахь зорилт СЗДҮАХ-ийн 1.1.4 дэх зорилт	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах	1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт 13 багийн дүнгээр 1284 цэргийн насны залуучууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдлаа. Сумын Засаг даргын Тамгын газар, Өрхийн эрүүл мэндийн төв, багийн Засаг даргын ажлын алба хамтран цэргийн комиссийн үзлэгээс өмнө шээсний ерөнхий шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг, биохими, серлогийн шинжилгээг урьдчилж

			<p>хийж шинжилгээний хариуг тэр даруй гаргасан нь эрүүл мэндийн үзүүлэлтийг үнэлэхэд эерэг үр дүнтэй ажил боллоо. Хамрагдсан залуучуудын 708 буюу 55.2 хувь нь эрүүл мэндээр тэнцсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 31.5 хувиар өссөн бөгөөд өсөлтийн үзүүлэлтэнд оюутнууд хамрагдсан нь эерэгээр нөлөөллөө. Цэрэг татлагад хамрагдсан 1284 иргэнээс серлогийн шинжилгээгээр 43 тэмбүүгийн өвчлөл илэрснийг багийн Засаг даргын ажлын алба, өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн ДОХ/БЗДХалдварт өвчний кабинаттай хамтран эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Сумын Засаг даргын Тамгын газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Багийн Засаг даргын ажлын албаны хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг 02 дугаар улиралд зохион байгуулж, тус үйл ажиллагаагаар цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах ажилд ахиц гаргах арга замыг тодорхойлж, үүрэг чиглэл өгөв. Эрүүл мэндээр тэнцэн цэргийн албанд татагдсан залуучуудыг Бүсийн оношлогоо эмчилгээний төвд 8 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулав.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
10.	<p>АЗДҮАХ-ийн 3.1.1.3 дахь зорилт</p>	<p>Тамхигүй ажлын байрны бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>ДЭМБайгууллага болон Эрүүл хотуудын холбоо ТББайгууллагаас зохион байгуулсан “Тамхигүй ажлын байр”-ны бодлогод нэгдэж Арвайхээр суманд ажилладаг төрийн болон хувийн хэвшлийн 15 байгууллагын 1070 гаруй иргэдийг хамруулав. Түүнээс 427 иргэнийг хамруулсан судалгааг аймгийн ЭМГазартай хамтран явуулсан. Судалгаагаар Та тамхи татдаг уу - 66,2% тийм Тийм бол гарахыг хүсдэг үү – 63,4% тийм Та сүүлийн 1 сарын дотор хэн нэгэн байгууллага дотроо тамхи татаж байгааг харсан уу – 92,7% үгүй Та сүүлийн 1 сарын дотор байгууллагын гадна Тамхи татаж байгаа хүнийг харсан уу – 95,7% тийм Та ажлын байранд тамхи татахад санаа зовдог уу – 91,5% тийм, дам тамхидалт түүнд өртсөн хүмүүс давхар өвчилдөг гэдгийг мэдэх үү – 58,7% үгүй Ажлын байранд тамхи татах нь хөдөлмөрийн бүтээмжид</p>

			<p>сөргөөр нөлөөлдөг гэдгийг мэдэх үү -74,4% үгүй Танай байгууллагад тамхигүй ажлын байрны бодлого хэрэгжүүлбэл та дэмжих үү – 61% дэмжинэ гэсэн хариултуудыг өгсөн байдаг. Түүн дээр дүгнэлт хийгээд хор хөнөөлийн талаар шинэлэг хэлбэрийн сургалт хийх, дотоод журамд тусгаж өгөх, тамхи татах цэгтэй болох, дотоод хяналттай болох, тамхины үйлдвэрлэл импортонд татварын системийн өөрчлөлт оруулж лобби бүлэг үүсгэн шийдвэр гаргагчдад нөлөөлөх, ЕБСургуулийн хүүхдүүдийн дунд “Тамхи татдаг найздаа” эссэ бичлэгийн уралдаан зарлах зэргээр ажиллах нь зүйтэй гэх мэтээр тамхигүй ажлын байр хамт олныг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тамхидалтын эсрэг хуулийн хүрээнд тамхийг сургууль цэцэрлэгийн орчноос 500 метрээс дотогш заруулахгүй, ширхэглэхгүй байх гэх мэт хуульд заасан зүйл заалтуудад хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
11.	СЗДҮАХ-ийн 1.1.4 дэх зорилт	5, 6 дугаар багуудын иргэдэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг ойртуулах	<p>5, 6, 13 дугаар багийн иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ойртуулах ажлын хүрээнд улсын төсвөөс 68 сая төгрөг шийдвэрлэн 02 дугаар сарын 01-ны өдрөөс хуучин өрхийн эрүүл мэндийн төвийн байранд засвар үйлчилгээ хийж, 3 эмч, 3 сувилагч, 1 үйлчлэгч, 1 сахиул нийт 8 орон тооны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
12.	СЗДҮАХ-ийн 1.1.5 дахь зорилт	Түр оршин суугчид болон 180 хоногоос дээш хугацаагаар оршин суудаг иргэдийн зардлыг өрхийн эмнэлгүүдэд шилжүүлэн олгох тогтолцоог бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх	<p>Түр оршин суугч, эрүүл мэндийн үйлчилгээ авдаг 0-5 насны 356, 6-15 насны 633 хүүхдүүд, 16-49 насны 1207 эмэгтэйчүүд, 60-аас дээш настай өндөр настан 376, бусад насны эрүүл мэндийн үйлчилгээ авсан 799 нийт 3371 иргэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг авч байгаа. Төсөв нь тухайн харьяатай газартаа байгаа, санхүүжилтийг шилжүүлэх боломжгүй учраас шийдвэрлэгдээгүй. Цаашид түр оршин суугч иргэдийг үндсэн оршин суугч болох шаардлагыг багийн Засаг дарга нарын ажлын алба, өрхийн эрүүл мэндийн төвөөс тавьж байх үүрэг чиглэлийг сумын удирдагаас өгсөн. Багийн Засаг дарга нарын ажлын алба түр оршин суугч болон шилжин ирсэн, шилжиж явсан иргэдийн мэдээллийг улирал бүр солилцож байна.</p>

			Үнэлэх боломжгүй
<p align="center"><i>а. 1.2 Боловсролын үйлчилгээ Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сурч боловсрох, хөгжих, бүтээлч хандлага суурилсан оюунлаг иргэнийг төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</i></p>			
13.	АЗДҮАХ-ийн 3.2.1.1, 3.2.1.2, 3.2.1.3 зорилт СЗДҮАХ-ийн 1.2.1 дахь зорилт	320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга барих	БСШУЯамны 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Мэргэд сургуулийн шинэ байрны барилга угсралтын ажил 90 хувьтай явагдаж байгаа, ондоо багтаж ашиглалтад орно. Үр дүнтэй 100
14.	АЗДҮАХ-ийн 3.2.1.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.2.2 дахь заалт	2, 4 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, ашиглалтад оруулах	БСШУЯамны 180 сая төгрөгийн санхүүжилтээр 2-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 4 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 170 сая төгрөгийн санхүүжилтээр баригдсан. Үр дүнтэй 100 хувь
15.	АЗДҮАХ-ийн 3.2.2.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.2.3 дахь заалт	11 дүгээр цэцэрлэгийг засварлах	Орон нутгийн төсвийн 7.5 сая төгрөгийн санхүүжилтээр хуучин байрны засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үр дүнтэй 100 хувь
16.	АЗДҮАХ-ийн 3.1.3.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.2.5 дахь заалт	Боловсролын салбарын багш нарыг “Шинэ бүтээл оновчтой санал” уралдаанд оролцуулах	11 дүгээр сарын сүүлийн 7 хоногт 1 дүгээр шат, 12 дугаар сарын эхний 15 хоногт 2 дугаар шатны уралдааныг зохион байгуулагдахаар аймгийн Боловсрол соёл, урлагийн газраас удирдамж, төлөвлөлт гарч, сургуулиуд оролцуулах багш, баг бүрэлдэхүүний бэлтгэлийг 100 хувь хангаж, 1 дүгээр шатны уралдаанд сумын хэмжээнд 189 багш буюу нийт багш нарын 45 хувь нь оролцов. Үр дүнтэй 100 хувь
17.	АЗДҮАХ-ийн 3.2.5.1, 3.2.6.1 дэх заалтууд СЗДҮАХ-ийн 1.2.5 дахь заалт	Боловсролын салбарын багш нарыг аттестатчилалд хамруулах	Аймгийн боловсрол, соёл урлагийн газраас бага боловсролын багш нарын ур чадвар, заах арга зүй, чадавхийг дээшлүүлэх, багш нарын ахиц, амжилтыг үнэлэх зорилгоор 3 үе шаттайгаар аттестатчилалд хамрууллаа. Сургуулиудын дундаж мэргэжлийн онол 63.7 хувь, сургалтын орчин 91.3 хувь, хөтөлбөр төлөвлөгөө 88.3 хувиар үнэлэгдэв. Үр дүнтэй 100 хувь
18.	АЗДҮАХ-ийн 3.2.6.2 дахь заалтууд СЗДҮАХ-ийн 1.2.5 дахь заалт	Боловсролын байгууллагын багш нарыг гадаад оронд сургалт хөтөлбөрт хамруулан мэргэжил боловсролыг	Хүүхдийн хөгжил хамгааллын зорилтот жилийн ажлын хүрээнд өндөр амжилт гаргасан 3 багшийг 2019 оны 07 дугаар сард Тайвань улсад, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үр дүнгээр амжилт үзүүлсэн 5 сургуулийн захирлыг

		дээшлүүлэх	БНСолонгос улс руу туршлага судлах, аялалд хамруулав. Япон улсын Такикава хотын хамтын ажиллагааны хүрээнд Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн 2 багшийг 6 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлсэн Үр дүнтэй 100 хувь
<i>1.3 Соёл, урлаг, спорт, нийтийн биеийн тамир: Түүх, өв соёлоо эрхэмлэн дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэн нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж, хүний хөгжлийг хангана.</i>			
19.	АЗДҮАХ-ийн 2.2.5.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.3.1 дэх заалт	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын аймгийн анхдугаар чуулганд иргэдийг оролцуулах	Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан Биет бус өвийг хамгаалах “Соёлын өв хөгжлийн дархлаа” форумд ажил хариуцсан мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, соёлын биет бус өв тээгч 6 иргэн оролцов. Тус форумгаас залуу хойч үе, иргэдэд уламжлалт ёс заншил, соёлын биет бус өвийг уламжлан өвлүүлэх олон талт үйл ажиллагааг уриалсан тунхаг бичиг гаргахаар шийдвэрлэсэн. Биет бус соёлын хүрээнд 6 төрөлд 29 биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулсан. Үр дүнтэй 100 хувь
20.	СЗДҮАХийн 1.3.1 дэх заалт	Сумын нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлэх	Улсын бүртгэлийн хууль шинэчлэн найруулагдаж, дагалдах журмууд гараагүй байгаа тул бүртгэлжүүлэх ажил хүлээгдсэн. Үл хөдлөх соёлын өвийн дурсгалууд нь сумын ЗДТГазар болон бусад холбогдох байгууллагуудад бүртгэлтэй байгаа. Үнэлэх боломжгүй
21.	АЗДҮАХ-ийн 2.4, 2.2.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.1.12 дахь заалт	Спортын чиглэлийн нэрэмжит болон бусад тэмцээнүүдэд баг тамирчдыг оролцуулах	ОУХМастер Д.Амарсанаа, спортын мастер Ж.Жанцандорж нарын нэрэмжит хөнгөн атлетик, шатрын аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнд 340 хүүхэд, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат дасгалжуулагч Ч.Насантогтохын нэрэмжит жүдо бөхийн өсвөр үеийн тэмцээнд 15 байгууллагын 200 тамирчин, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд зохион байгуулсан тэмцээнд 13 багийн 182 тамирчид, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх оюун ухаан, авхаалж самбааг сорих, волейбол, ширээний теннис, дардсын төрлүүдээр явагдсан тэмцээнд 15 багийн 198, давхардсан тоогоор 1000 гаруй тамирчид оролцлоо. Үр дүнтэй 100

22.	АЗДҮАХ-ийн 2.5-2.2.1 дэх заалт СЗДҮАХ-ийн 3.1.12 дахь заалт	Ерөнхий боловсролын сургуулиудын спорт залуудыг хөл бөмбөгийн спортоор хичээллэхэд аюулгүй ажиллагаа хангасан орчин бүрдүүлэх, тоон электрон самбартай болгох ажлыг судлах	Улсын төсвийн 130 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2, 4 дүгээр сургуульд хөл бөмбөгийн талбайтай болсон. Ерөнхий боловсролын сургуулиудын спорт залны орчин нөхцөл, спортын хэрэглэгдэхүүнийг сайжруулах зорилгоор 2020 оны улсын төсөвт сургууль тус бүрт 10 сая нийт 60 сая төгрөгийг тусгуулсан. Үр дүнтэй 100 хувь
23.	СЗДҮАХ-ийн 1.3.3 дахь заалт	Урлаг, спортын наадмыг зохион байгуулах	Санхүүжилтийн эх үүсвэргүй тул 2020 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан. Үнэлэх боломжгүй
<i>1.4 Хүүхэд, залуучууд, ахмадуудын гэр бүлийн хөгжил: Хүүхэд, залуучууд, ахмадуудын гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бодлого үйл ажиллагаанд тулгуурлан хүүхэд, гэр бүлийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ</i>			
24.	АЗДҮАХ-ийн 3.5.1.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.4.2 дахь заалт	Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд “Залуус хөгжлийн танхим”-тай хамтран үйл ажиллагаа зохион байгуулах	Аймгийн Залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан хөтөлбөр, арга хэмжээнүүдэд сумын залуучуудыг өргөнөөр татан оролцуулж байна. “Тогтвортой гэр бүл-Улсын үндэс” залуу гэр бүлийн өдөрлөгт 13 баг тус бүрээс 1 залуу гэр бүлийг оролцуулж, “Хамгийн залуу өнөр гэр бүл” номинацид 13 дугаар багийн А.Дэмбэрэлнямбуугийн гэр бүл шалгарч, батламж гардан авлаа. Хүүхдийн байгууллагын үүсч хөгжсөний 94 жилийн ойн хүрээнд “Өвөрхангайн хүүхдүүд шинэ зууны элч” өдөрлөгийг ЕБ-ын сургууль, МСҮТөв, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 200 хүүхдийг хамруулсан. “Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбоо”-оос зохион байгуулсан “Нар дагуулсан залуу нас-2” залуучуудын чуулга уулзалтад Арвайхээр сумаас 650 залуучуудын төлөөлөл оролцож, дуу хоолойгоо хүргэсэн. Аймгийн Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран “Залуусын хүч” уриан дор “12 санаачлага-12 ажил” сарын аянг зохион байгуулж төрөл бүрийн уралдаан тэмцээн, арга хэмжээнд 1200 залуусыг хамрууллаа. Залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Хувь хүний манлайлал” сургалтад ерөнхий боловсролын 5 сургуулийн ахлах ангийн болон Политехник коллежийн 800 гаруй хүүхдүүд хамрагдсан.

			Үр дүнтэй 100 хувь
25.	АЗДҮАХ-ийн 3.5.2.4 дэх заалт СЗДҮАХ-ийн 1.4.4 дэх заалт	Хүүхэд хамгааллын байр барих	Хүүхэд хамгааллын байрыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн өртгөөр барьж, 2020 оны 1 дүгээр сараас ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Үр дүнтэй 100 хувь
26.	АЗДҮАХ-ийн 3.5.1.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.4.2 дахь заалт	Хүүхдийн ордны дэргэдэх дугуйлан, секц, хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаанд хүүхдүүдийг хамруулах	Хүүхдийн ордны дэргэдэх дугуйлангийн багш нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, 11 сарын байдлаар 822 хүүхэд 20 төрлийн дугуйлан, сургалтад хамрагдаж байна. Зорилтот өрхийн 25 хүүхдийг бүжиг, шатар, даам, хөгжмийн дугуйланд үнэ төлбөргүй хамруулж, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлсэн. Үр дүнтэй 100 хувь
27.	АЗДҮАХ-ийн 35.1.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 1.4.2, 3.2.6 дахь заалт	Хүүхдийн паркад зарим тоглоомын шинэчлэл хийх	Хүүхэд залуучуудын паркад том алсыг харагчийг ашиглалтад орууллаа Гэрэлтүүлгийг 27 сая төгрөгөөр шинээр тавьж, хөл бөмбөгийн талбайг 250 сая төгрөгөөр бүрэн шинэчилсэн. Үр дүнтэй 100 хувь
<i>1.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, Ажлын байрыг нэмэгдүүлэн ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлэн нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.</i>			
28.	АЗДҮАХ-ийн 3.4.1 дэх зорилт СЗДҮАХ-ийн 1.5.1 дэх зорилт	Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг зохион байгуулах	Аж ахуй нэгж, байгууллагуудаас авсан ажлын байрны мэдээгээр нийт 264 ажлын байр, түр ажлын байр 140, сум хөгжүүлэх сангийн зээлээр 18, Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд 181 буюу нийт 603 байнгын болон түр ажлын байр бий болж, 2019 оны төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар 80.4 хувьтай хэрэгжиж байна. Үүнд: “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бүлийн зохион байгуулалттай төмс, хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 8 бүлийн 32 иргэн 15.0 сая төгрөгийн ажлын байрыг дэмжих төсөлд 98 иргэнд 285 сая, нийтийг хамарсан ажилд 140 иргэн хамрагдаж 53.2 сая төгрөгийн цалин, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 30 иргэнд 65 сая төгрөгийн зээл, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 23 иргэнд /хэрэгжих шатандаа/, Ахмадын зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөлд 14 ахмад хамрагдаж 5.8 сая төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт 16 ахмад хамрагдаж 28.5 сая төгрөг,

			нийт 452.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Үрдүнтэй 100 хувь
29.	АЗДҮАХ-ийн 3.4.1.4 дэх заалт ЗДҮАХ-ийн 1.5.2 дахь зорилт	“Нэг өрх - Нэг ажлын байр” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	2019 онд байнгын ажлын байранд 71 иргэн, түр ажлын байранд 91 иргэн хамрагдсан. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны өөрчлөлт, өсөлтөд явцын үнэлгээ хийхэд нийт өрхийн 94.5 хувийг байнгын болон түр ажлын байр, зээл, дэмжлэгт хамруулсан байна. Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн хэрэгцээний судалгааг нарийвчлан гаргаж, өссөн дүнгээр хүнс тэжээлийн үйлчилгээнд 71 өрх, хүсэлт гаргасан 56 өрхийн 54 өрх буюу 96.4 хувь өөрийн өмчлөлийн газартай болсон. Сумын “Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрт өссөн дүнгээр 360 өрхийн 1835 иргэнийг хамруулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн Хуралдаанд хэлэлцүүлэн, 92 дээш хувиар үнэлүүлсэн. Жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хувь хүний хөгжил сэтгэл зүйн байдал хандлагыг талаарх судалгааны үр дүн болон хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нь үндэслэн мэргэжлийн сургалтад /зөөлөн эдлэлийн оёдол эсгүүрчин, тогооч, барилгын засал чимэглэлч/ 15н иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.0 сая төгрөгийг зарцуулж, сургалтад хамрагдсан иргэдийн 40 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэн, 30 хувь нь ажлын байраар хангагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 55 иргэн, бизнес төсөл боловсруулах арга аргачлалд сургах аж ахуйн эрхлэлтийн сургалтанд 65 иргэн тус тус хамрагдсан. Үр дүнтэй 100 хувь
30.	АЗДҮАХ-ийн 3.4.1 дэх зорилтын 3 дахь заалт ЗДҮАХ-ийн 1.5.3 дахь зорилт	Шинээр ажлын байр олноор бий болгосон, тогтвортой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг дэмжих	2019 онд 8 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан түрээсийн дэмжлэг үзүүлж ажилласан. Ажлын байраа тогтвортой хадгалж, ажилчдынхаа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн 14 аж ахуйн нэгжид 2018-2019 онуудад ажил олгогчийн дэмжлэгийг ХЭДСангаас олгож,

			<p>өссөн дүнгээр 11 иргэнийг байнгын ажлын байраар хангаж нийт 16.8 сая төгрөгийн дэмжлэг олгогдсон. Сум хөгжүүлэх сангаас 2019 онд 19 эмэгтэйд зээл олгож, эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг бодлогын түвшинд дэмжиж ажиллаа.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
31.	СЗДҮАХ-ийн 1.5.4 дэх зорилт	<p>Ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээлэл өгөх, ажилд зуучлах үйлчилгээнд иргэдийг хамруулах</p>	<p>“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бүлийн зохион байгуулалттай төмс, хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 8 бүлийн 32 иргэн 15.0 сая төгрөгийн, ажлын байрыг дэмжих төсөлд 98 иргэнд 285 сая төгрөгийн, нийтийг хамарсан ажилд 140 иргэн хамрагдаж 53.2 сая төгрөгийн цалин, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 30 иргэнд 65 сая төгрөгийн зээл, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 23 иргэн, Ахмад настны зөвлөх үйлчилгээ үзүүлэх төсөлд 14 ахмад хамрагдаж 5.8 сая төгрөг, ахмадын санхүүгийн дэмжлэгт 16 ахмад хамрагдаж 28.5 сая төгрөг, нийт 452.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. ДЗОУБайгууллагаас хэрэгжүүлсэн “Өрхийн хөгжил-320” төслийн хүрээнд Арвайхээр сумын 4н багийн 163 өрх тоног төхөөрөмж, 24 өрх хургатай хонь төсөлд 78.720.0 төгрөгийн зээл тусламж авч, 100 хувь ажлын байраар хангагдсан.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
32.	АЗДҮАХ-ийн 3.4, 3.1 дэх заалт ЗДҮАХ-ийн 1.5.5 дахь зорилт	<p>Аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны аюулгүй байдал, цалин хөлсийг ажилласан цагаар олгодог тогтолцооны хэрэгжилтийг хангах</p>	<p>2019 онуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зарлаж, тус аяны хүрээнд Арвайхээр сумын Засаг даргын 2017 оны А/44 дүгээр захирамжаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг байгуулж ажилласан. Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах, цалин хөлсний тогтолцоог оновчтой, ил тод болгох, ажлын хөлсийг ажилласан цагаар олгох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шатахуун түгээх станцуудад хяналт шалгалт хийхэд хөдөлмөрийн гэрээнд цалингийн хэмжээг тусгаагүй зөрчил илэрсэн. Зөрчлийн дагуу зөвлөмж хүргүүлж ажилласнаар ажлын хөлсийг ажилласан цагаар олгох нөхцөл бүрдсэн бөгөөд ЗДТГазрын 03/107 дугаарын зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн ажлын</p>

			<p>төлөвлөгөөний дагуу дахин хяналт шалгалт хийхэд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 91.7 хувийн үнэлгээтэй хэрэгжиж байгаа талаар бодит үр дүн гарч өмнөх үеэс 6.1 хувиар өссөн байна.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлуулж, сумын ИТХуралтай хамтран дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг томоохон 6 аж ахуй нэгжийн 9 уурын зуухыг хамруулсан. Үүнд: “Арвай-Илч” ХХК, “Хөтөлт-Илч” ХХК, “Өв-Илч” ХХК, “Арвай плас” ХХК, “Өв пост” ХХК, “Мөнх-Осго” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдэд “Хөдөлмөрийн тухай” хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр хангаж ажиллахад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 73.1 хувийн үнэлгээтэй хэрэгжиж байгаа ахисан үр дүн гарлаа. Засаг даргын 01/75 дугаарын зөвлөмжийг хүргүүлж, дахин хяналт хийхэд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулиуд 85.5 хувийн үнэлгээтэй хэрэгжиж өмнөх үеэс 12.4 хувиар өссөн эерэг үзүүлэлт гарлаа. 2019 онд дээрх аж ахуй нэгжүүд болон ЭБЦТТӨХХК, барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг томоохон аж ахуй нэгжүүдэд зөвлөн туслах ажил хийж ажилласан</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
33.	<p>АЗДҮАХ-ийн 3.4.3.1 дэх заалт ЗДҮАХ-ийн 1.5.6 дахь зорилт</p>	<p>Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжилтэй ажилтанг мэргэжлийн болон давтан сургалтаар бэлтгэж, биз нес эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд нь зориулж хүү багатай, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамруулах</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хувь хүний хөгжил сэтгэл зүйн байдал хандлагыг талаарх судалгааны үр дүн болон хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нь үндэслэн мэргэжлийн сургалтад /зөвлөн эдлэлийн оёдол эсгүүрчин, тогооч, барилгын засал чимэглэлч/ 15 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан. Сургалтад хамрагдсан иргэдийн 40 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж, 30 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 55</p>

			иргэн, бизнес төсөл боловсруулах арга аргачлалд сургах аж ахуйн эрхлэлтийн сургалтад 65 иргэн хамрагдсан байна. Сумын хэмжээнд гэрийн ажилтай болон хүүхэд өндөр настан асардаг эмэгтэйчүүдэд зориулсан өдөрлөг зохион байгуулж, 13 багийн 80 эмэгтэй оролцон, гэр бүлийн харилцаа, үнэ цэнэ, ёс зүйн чиглэлээр сургалт хийсэн. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв”-ийн нээлтийн үйл ажиллагаанд хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн болон гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн төлөөлөл бүхий 260 иргэн хамрагдсан. Барааны захын гадаа ил задгай олон жил худалдаа хийсэн 13 иргэнд олон улсын төслийн байгууллагатай хамтран зориулалтын павилонтой болгож хүүгүй зээлд хамрууллаа. Үр дүнтэй 100 хувь
Салбарын дундаж 100 хувь			
2. Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн бодлого зохицуулалт			
2.1 Жижиг дунд үйлдвэр, хувийн хэвшлийг дэмжих: Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санал, санаачлагыг дэмжин ажиллаж, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ.			
34.	АЗДҮАХ-2.2.1.5 дахь зорилт Сумын ЗДҮАХ-2.1.3 дахь зорилт	Хүнсний ногоо даршлах, савлах үйлдвэр, цехийн төсөл, хөтөлбөрийг дэмжих	Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Өрхийн хөгжил-320” төслийн хүрээнд Арвайхээр суманд төмс, хүнсний ногоо боловсруулах, технологийн болон маркетингийн анхан шатны 8 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 420 гаруй иргэн хамрагдсан. 4 дүгээр багийн иргэн Э.Мөнхнасангийн хүнсний ногоо боловсруулах “Nasa” цехд вакуумжуулсан аппарат, хүнсний вакум уут бүгд 1,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж төслөөс олгосон. Сум хөгжүүлэх сангаас Бүтээлч дэвшил хоршоонд ногоо даршлах, савлах үйл ажиллагааг дэмжин 15 сая төгрөгийн зээл олгосон. Бизнесийн шинэ санаа нэвтрүүлэх ТББайгууллага Япон улсын Хоккайдо мужын Такикава хоттой хамтран “Өвсний үндэс” төслийг хэрэгжүүлж ЖАЙКА-ийн 26 сая төгрөгийн санхүүжилтээр “Газар тариалангийн загвар аж ахуйг” байгуулах зорилгоор нарлаг хүлэмж 2, гүний худаг 1-ийг шинээр барин үйл ажиллагаа явуулж байна. Тус төслийн хүрээнд 2 иргэнийг 1 сарын хугацаатай хүнсний ногоо боловсруулах сургалтад хамруулав.

35.	<p>АЗДҮАХ-2.1.6 дахь зорилт Сумын ЗДҮАХ -2.1.4 дэх зорилт</p>	<p>Арьс, шир болон төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл байгуулах, өргөжүүлэх санал санаачлагыг дэмжих</p>	<p style="text-align: center;">Үр дүнтэй 100 хувь</p> <p>“Арвайхээр сумын “Арвин шунхлай” хоршоо нь 2017 онд Австралийн Элчин сайдын яамны 36.9 сая төгрөгийн санхүүжилтээр сард 700-800 ширхэг арьс, нэхий болон ишиг, хурганы арьс боловсруулах хүчин чадалтай цехийг ашиглалтад оруулсан. Орон нутгаас үйлдвэрийн байр барих газрын асуудлыг шийдвэрлэн дэмжиж, “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас 65.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж үйлдвэрийн барилгаа 90 хувийн гүйцэтгэлтэй барьж байна.</p> <p>“Өв сор хангай” ХХК Арвайхээр суманд өдөрт 500 ширхэг богийн арьс, нэхий, 1500 ширхэг бодын ширэнд анхан шатны боловсруулалт хийх хүчин чадалтай үйлдвэр байгуулахаар, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас 700.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Одоогийн байдлаар үйлдвэрийн байраа барьж дууссан, тоног төхөөрөмжөө суурилуулах бэлтгэл ажил хийгдэж, энэ онд ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна. “Ноос ирээдүй” ХХК 2017-2019 онд 5.0 мянган тн ноос угааж, 175 тн ноосыг самнаж анхан шатны боловсруулалт хийж үндэсний үйлдвэр болон экспортод нийлүүлээд байна. Мөн үйлдвэрийнхээ дэргэд эсгийний үйлдвэр, зөөлөн оёдлын цех байгуулан, хонины ноосон хөнжил, гудас, аяны ком, ажлын хувцас, өвлийн хүрэм зэрэг оёмол бүтээгдэхүүн, 56.8 мянган метр эсгий тус тус үйлдвэрлэж, 1033.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн зах зээлд борлуулсан байна.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зөөлөн оёдлын үйлдвэр байгуулагдаж, “Хээлэн” брэндийн хонины ноосон хөнжил үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж эхлээд байна.</p> <p>Мөн “Бат зүү” оёдлын үйлдвэрийн салбар “Топ зүү” үйлдвэр 2018 онд ашиглалтад орж нийт 375.9 сая төгрөгийн 4476 ширхэг сурагчийн дүрэмт хувцас болон ажлын хувцас, “Monline” ХХК-ний салбар “Зуун зуун зураас” ХХК 315.1 сая төгрөгийн 5100 спортын хувцас үйлдвэрлэж зах зээлд нийлүүлээд байна.</p>
-----	---	--	--

			Үр дүнтэй 100 хувь
36.	АЗДҮАХ-2.2.1.8 дахь зорилт Сумын ЗДҮАХ -2.1.5 дахь зорилт	“Арвайхээрт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Нутгийн брэнд бүтээгдэхүүн гаргах, олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэдийг “Цагаан сар-2018” үзэсгэлэн худалдаанд оролцуулснаар 16 иргэн, 4 аж ахуйн нэгж, 2 хоршоо нийт 22 иргэн, аж ахуйн нэгж оролцож 4 өдрийн хугацаанд 23.500.000 төгрөгийн борлуулалт хийсэн. “Өв –Түншлэл 2019 ” оны үзэсгэлэн худалдаанд 42 иргэн, аж ахуй нэгж бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан 29 сая төгрөгийн борлуулалт хийсэн.Үзэсгэлэн худалдааны үеэр зохион байгуулагдсан номинацаар: -“Шилдэг гар урлал” номинацид 7-р багийн Даваамаа, “Хөдөлмөр хөнгөвчилсөн Хөдөө аж ахуйн шилдэг бүтээл” номинацид 11-р багийн Ж.Батнасан, “Орон нутгийн шинэлэг бүтээгдэхүүн” номинацид Политехникийн коллежийн бууцайтай гурил, “Орон нутгийн шилдэг, гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн” номинацид Сандагсүрэн, “Шилдэг цагаан идээ”номинацид Одод ааруулын цех, “Хөнгөн үйлдвэрийн шилдэг” номинацид Арвин шунхлай хоршоо тус тус шалгарав. Үр дүнтэй 100 хувь
37.	Сумын ЗДҮАХ - 2.1.6 дахь зорилт	Ашиглагдахгүй байгаа барилга объектуудыг бизнес хөгжлийн төвийн байр болгож төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эдийн засгийн эргэлтэд оруулахыг судлан шийдвэрлүүлэх.	“2019 онд ноосон болон оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байраар хангах зорилгоор “Түшиг дөлгөөн” өрхийн эмнэлгийн хуучин барилгыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр засварлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зөөлөн оёдлын үйлдвэр байгуулагдаж, “Хээлэн” брэндийн хонины ноосон хөнжил үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна. Ашиглагдахгүй байгаа 3 дугаар багийн төвийн байранд суудлын бүрээс, алт мөнгөний дархан, сүлжмэлийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийн үйлдвэрлэлийн үйл ажилагааг дэмжин ажлын байраар ханган ажлуулж байна. Үр дүнтэй 100 хувь
38.	АЗДҮАХ-ийн 2.4.2.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 2.2.1 дэх зорилт	Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай зохион байгуулж, голомтот нутгийн мал сүргийг бүрэн хамруулах	2019 онд Арвайхээр сумын 4 аж ахуйн нэгжийн тархвар зүйн судалгааг үндэслэн аж, ахуйн нэгжүүдийн захиалгаар мал, амьтны 8 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 361,5 литр вакцин нийлүүлэгдсэн. 1174 өрхийн 76250 мянган мал хамруулах төлөвлөгөөтэйгөөс

			одоогийн байдлаар 400 гаран өрхийн 54 мянган толгой мал буюу 100 хувь нь хамрагдаад байна. Үр дүнтэй 100 хувь
2.2 Хүнс, хөдөө аж ахуй: Бэлчээрийн даацад тохируулан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадварыг бий болгон хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, орчны эрүүл ахуйг сайжруулна.			
39.	АЗДҮАХ-2.1.3 дахь зорилт СЗДҮАХ -2.1.2 дахь зорилт	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах, өргөжүүлэх санал санаачлагыг дэмжих	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр сум хөгжүүлэх сангаас 2019 онд 3 иргэн, аж ахуй нэгжид 18 сая төгрөгийн зээл олгосон. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Өрхийн хөгжил-320” төслийн хүрээнд 2 иргэнд сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх санал санаачлагыг дэмжин цөцгий цохих машин, ааруул хатаагч зэрэг 3,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сүү цагаан идээний үйлдвэрлэл эрхлэгч Бүргэтэй хайрхан, Номин тансаг зэрэг аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллав. 2019 онд дээрх аж ахуй нэгжүүд үдийн цай хөтөлбөрт 180 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үр дүнтэй 100 хувь
40.	СЗДҮАХ-2.2.3 дахь зорилт	Эрчимжсэн болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх	Аймгийн ХХААГазраас зохион байгуулсан “ Аймгийн эрчимжсэн мал аж ахуйн өнөөгийн байдал цаашдын зорилт” хэлэлцүүлэгт эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг 7 иргэнийг оролцуулж, ТАН ӨГӨӨЖ ХХКомпаний захирал,фермер эрхлэгч Н.Энхболд туршлагаасаа солилцож мэдээлэл хийв. Хэлэлцүүлэгт оролцогчид Төв аймгийн Баянчандмань суманд туршлага судаллаа.Үүнд “Баян шувуу” 300,0 мянган өндөглөгчтэй шувууны аж ахуй, ГМЭБ бордооны үйлдвэр, Сүүн далай хоршооны сүүний цех, Монбеллард үүлдрийг цэврээр нь үржүүлж буй саалийн механикжсан ферм зэрэг аж ахуйн нэгжүүдээр орж явуулж байгаа үйл ажиллагаатай танилцлаа. Туршлага судлахад оролцсон малчид цаашид энэ үйл ажиллагааг улам өргөжүүлж зохион байгуулалтад оруулж жил бүр туршлага судлах ажиллагааг өргөжүүлэн ажиллахыг хүсч байлаа. “Арвайн талын ургац” ХХК нь “Сум хөгжүүлэх сан”-гийн 15.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 1500 өндөглөгч бүхий тахианы аж ахуй байгуулан хоногт 700-800 өндөг зах

			<p>зээлд нийлүүлж, 3 хүнийг байнгын ажлын байраар хангаад байна. Сум хөгжүүлэх сангаас “Нүнжиг сүү” ХХК-д 10 сая төгрөгийн зээл олгосон. Тус компани мах, сүүний чиглэлийн Алатау үүлдрийн үхэр худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Сумын дүнгээр 2019 онд 276 эрлийз үхрээс 23,4 мянган литр сүү сааж, 88 мянган тн мах зах зээлд борлуулсан байна.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
41.	СЗДҮАХ-2.2.7 дахь зорилт	Усалгаатай тариалан, хөрс хамгаалах, техник технологийн дэвшил, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар төмсний 90, хүнсний ногооны 35, жимс жимсгэний 0.5 хувийн хэрэгцээг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлэх	<p>Каритас монгол төсөлтэй хамтран УГТЭШХүрээлэнгээс багш авчран төслийн тариаланчид болон сумын тариаланчдын төлөөллийг оролцуулан 3 өдрийн “Ургамал хамгаалал, хөнөөлт организмтай тэмцэх арга”-ын талаар сургалт мэдээллээр хангаж ажиллаа.</p> <p>Дархан уул аймгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс зохион байгуулсан “Хөнөөлт организмтай тэмцэх” арга хэмжээ, ургамал хамгааллын цогц арга сэдэвт сургалтад сумын газар тариалан хариуцсан мэргэжилтэн 2 тариаланчийн хамт хамрагдаж мэдлэг арга зүйгээр хангагдлаа.</p> <p>Дархан уул аймгийн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран 1-р багийн тариаланч В.Болорцогт, Г.Амгаланбаяр, 11-р багийн тариаланч П.Гэрэлт-од, П.Оюун, 1-р багийн тариаланч Э.Энхбаатар нарын хөрсний дээжийг журмын дагуу авч шинжилгээнд хамруулан шинжилгээний дүнд үндэслэн зохих арга хэмжээг авч ажиллаж байна.</p> <p>2019 онд төмс 67.9 га-д тариалж 795,5 тн ургац, хүнсний ногоо 34.7 га-д тариалж 353,5 тн ургац, малын тэжээл 66.5 га-д тариалж 225,5 тн ургацыг тус тус хураан аваад байна. Энэ нь урд оноос төмс 0.8 га, хүнсний ногоо 6.1 га, ногоон тэжээл 60га талбайгаар тус тус нэмэгдсэн дүнтэй байна..</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
42.	АЗДҮАХ-2.5.1 дэх, СЗДҮАХ-2.2.8 дахь зорилт	Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологи нэвтрүүлж, Дайргын голын хойд хэсгийн услалтын систем, үерийн далан	<p>Сумын тариаланчдын зөвлөгөөний үеэр тариаланчид Дайргын голын услалтын системийг засаж сайжруулах талаар санал тавьсан. Энэ асуудлыг тариаланчидтай хамтран ажиллаж, засаж сайжруулахаар сумын ЗДТГазар 1 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдсэн.</p> <p>4 дүгээр багийн иргэн Х.Цэцэгмаа өөрийн хөрөнгө</p>

		байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг судлан органик бордооны цех, хүнсний ногооны төрөлжсөн зоорь /энгийн болон автомажсан, механикжсан/ байгуулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх.	оруулалтаар органик бордооны өрхийн үйлдвэрлэл байгуулж 6 тн бордоо үйлдвэрлэн ХХҮГазрын бүлийн төсөлд нийлүүлээд байна. 5 дугаар багийн иргэн Энхболд хувийн хөрөнгө оруулалтаар өвлийн хүлэмж байгуулах санаачлага гарган хүлэмж барих ажлын явц 30 хувьтай байна. СХСангийн санхүүжилтээр өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор “Бүтээлч дэвшил” хоршоонд 15сая төгрөгийн дэмжлэг олгон үйл ажиллагааг өргөжүүлэн төмс 1га-д тариалж 12 тн ургац, хүнсний ногоо 0,51 га-д тариалж 6,1 тн ургац тус тус хураан авсан. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Өрхийн хөгжил-320” төслийн хүрээнд Арвайхээр сумын 13 иргэнд хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх зорилгоор 18,6 сая төгрөгийн эд материал, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна. 2019 онд хүлэмжээс 6,5 тн хүнсний ногоо хураан авсан. Арвайхээр суманд нийт 52 тариаланч нарлаг буюу зуны хүлэмж, 10 парник, 1 өвлийн хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Үр дүнтэй 100 хувь
43.	АЗДҮАХ-ийн дэх заалт Сумын 2.2.9 дэх зорилт	2.4.5.1 ЗДҮАХ-ийн “Атрын 60 жил”-ийн ойн хүрээнд сумын газар тариалангийн салбарыг ажиллагсдын бүртгэл мэдээллийг нарийвчлан гаргаж шагнал урамшуулалд тодорхойлох	Монгол улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн хүрээнд төрийн одон медальд 27 иргэн, Хүнс, хөдөө аж ахуйн тэргүүнд 19, Жуух-д 10 иргэн нийт 56 иргэний материалыг харьяалагдах багуудаас авч нэгтгэн хүргүүлснээр 36 иргэн төр засгийн одон медалиар, 62 тариаланч 60 жилийн ойн медалиар шагнууллаа. Үр дүнтэй 100 хувь
44.	СЗДҮАХ-2.2.10 дахь зорилт	Чацаргана бусад жимс жимсгэнэ, хүнсний болон эмчилгээний ач холбогдол бүхий ховор ургамал, эрт ургацын хүнсний ногооны тариалалтыг хөгжүүлэх.	Энэ онд 13 багийн иргэдээс захиалга авахад 41 иргэн жимсний модноос 614 ширхэгийн захиалга өгч хаврын тариалалтаар чацарганы 200 ширхэг суулгац нийлүүлэгдсэн. “Эмчилгээний ач холбогдол бүхий артишок ургамлыг 5 иргэн хүлэмжид, хүрэн манжинг 2.7 га талбайд тариалж тус тус эмчилгээний болон хүнсний зориулалтаар иргэдийн хүнс тэжээлийн хэрэгцээнд ханган нийлүүлээд байна. 11-р багт иргэн Мягмаржав 1500м2 газар жимс жимсгэний мод бүт үржүүлж 1500ширхэг хайлаас, улаалзгана, үхрийн нүд, нохойн хошуу, далан хальс тарьсан. Хүлэмжид эрүүл ахуйд сайн

			<p>артишок 30 бут, улаан буудайн соёолж ургуулж шүүсийг шахан авч эмчилгээний зориулалтаар ашиглаж байна. Зорилтот жилийн хүрээнд 22 өрх чацаргана 141 ширхэг, үхрийн нүд 24 ширхэг, монос 6 ширхэг, бөөрөлзгөнө 14, улаалзгана 5 ширхэг, чавганы мод 4, долоогоно 2 ширхэг, эмийн ургамал 18 ширхэг бутыг тарьж ургуулсан</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
Салбарын дундаж 100 хувь			
3. Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлого зохицуулалт			
<i>3.1 Байгаль орчин, газар зохион байгуулалт: Хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн агаар, хөрсний бохирдлыг бууруулж, ухаалаг хот буюу ногоон хотыг бий болгоно.</i>			
45.	<p>АЗДҮАХөтөлбөрийн 1.1. 3.3 дахь заалт СЗДҮАХөтөлбөрийн 3.1.1 дэх заалт</p>	<p>Д.Пүрэвдоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах</p>	<p>Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу зам талбайг тохижуулах тохижилтын ажлын зураг хийгдсэн боловч Мэргэд сургуулийн өргөтгөлийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор түр хойшлогдож, 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан.</p> <p>Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь</p>
46.	<p>АЗДҮАХ-ийн 1.1.3.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.1.1 дэх заалт</p>	<p>Зарим нэрэмжит гудамжнуудын тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх</p>	<p>2019 онд Т.Намнансүрэнгийн гудамжинд 12360 ширхэг хайлаас, Ренчинпэлжээгийн гудамжинд 177 ширхэг улиас, 3-р багийн авто зам дагуу 294 ширхэг улиас, А0301 улсын чанартай авто замын дагуу 188 ширхэг улиас тус тус тариалсан бөгөөд усалгаа арчилгааг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ хариуцан гүйцэтгэж амьдралт 95 хувьтай байна.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
47.	<p>АЗДҮАХ-ийн 1.1- 1.2.1 дэх заалт СЗДҮАХ-ийн 1.1.2.3 дахь заалт</p>	<p>Төв суурин газрын ундны усны эх үүсвэрийг тоолууржуулах, “Дэлгэрэх” гол төслийг үе шаттайгаар үргэлжлүүлэх</p>	<p>2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалт удирдамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, Онги таац голын сав газар болон, Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын баталсан удирдамжаар тус сумын газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд “Монгол Улсын усны тухай хууль” “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хууль болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тушаал ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам зэрэг хууль тогтоомжийн дагуу шалгалтын ажил явагдлаа. Дээрх шалгалтаар 13 газарт хугацаатай албан шаардлага хүргүүлэн 2 газрыг тоолууржуулж 2 иргэний усны тоолуурийг баталгаажуулалт засвар үйлчилгээнд хамрууллаа. Дэлгэрэх гол төслийн хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, төрийн бус байгууллагын хандиваар нийт 9.3 га талбайд</p>

			<p>модлог ургамлын төгөл бүхий цэцэрлэгт хүрээлэн 2, амрах талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж, нарс, монос, бургас, улиас зэрэг нэр төрлийн 7300 ширхэг мод бут тарьсан бөгөөд амьдралт 87 хувьтай байна. Мод бутны нүх ухах, зүлэгжүүлэлтийн хөрс бэлдэх ажлыг 2000 орчим төрийн албан хаагчид гүйцэтгэсэн.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
48.	<p>АЗДҮАХ-ийн 1.1.3.3 дахь заалт</p> <p>СЗДҮАХ-ийн 3.1. 1 дэх заалт</p>	<p>Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазарт туршилт судалгааны өвлийн хүлэмж байгуулах</p>	<p>Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазрын 2019 оны төсөвт батлагдаагүй тул БТМ ХХК-ны өвлийн хүлэмж бүхий мод үржүүлгийн талбайг бартерийн аргаар дүйцүүлэн худалдан авахаар 2020 оны төсвийн төсөлд тусгагдсан.</p> <p>Үнэлэх боломжгүй</p>
49.	<p>СЗДҮАХ-ийн 3.2.3 дахь заалт</p>	<p>Үерийн далан шуудуу татах, газрын хотгор гүдгэрийг тэгшлэх</p>	<p>2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн 5 сая төгрөгийн хөрөнгөөр 13 багийн нутаг дэвсгэрт 3040 м² талбайн рельефийг тэгшлэх, шороо дүүргэх ажлыг иргэн Д.Буманнасттай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
50.	<p>СЗДҮАХ-ийн 3.1.7 дахь заалт</p>	<p>Нийтийн эзэмшлийн зам талбайн шаардлагатай газруудад нийтийн бие засах газар байгуулах</p>	<p>2019 оны аймгийн төсөвт батлагдсан 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг хагас жилийн төсвийн тодотголоор өөр ажил үйлчилгээнд шилжүүлсэн.</p> <p>Үнэлэх боломжгүй</p>
51.	<p>СЗДҮАХ-ийн 3.1.8 дахь заалт</p>	<p>Хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэр байгуулсан иргэн аж ахуй нэгжийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх</p>	<p>Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 9 сая төгрөгийн хөрөнгөөр Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын 5ширхэг хогийн савыг иргэн Б.Наранбаатар хийж гүйцэтгэсэн бөгөөд тус хогийн савнуудыг нийтийн эзэмшлийн зам талбай, ЕБ-ын 1 дүгээр сургууль,орон сууцны гадна талбайд байрлуулан хог хаягдлыг Цэмцгэр хоёрдогч түүхий эдийн төв цуглуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Цэмцгэр төв нь хуванцар сав, гялгар уут, лааз гэх мэт дахин ашиглах боломжтой хаягдлыг худалдан авах, борлуулах үйл ажиллагааг явуулдаг. Монголын хог хаягдлын холбоо, хог хаягдлыг тандах судлаачдын холбооны гишүүн доктор Эрдэнэ Арвайхээр хотод “Хог хаягдлын менежмент” сургалтыг зохион байгуулж, орон нутагт хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах нь эдийн засгийн хувьд алдагдалтай гэж үзсэн. Цаашид дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хэмжээг нь багасгаж шахах /преслэх/, бутлах тоног төхөөрөмжийг ТҮК-ын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр түүхий эд</p>

			<p>бэлтгэн үйлдвэрүүдэд нийлүүлэх хог хаягдлаас орлого бүрдүүлэх, хогийн цэгт хаягдах хог хаягдлын хэмжээг багасгах давуу талыг харж, хэрэгжүүлэхээр Дэлхийн банкны төслийн багатай хамтран 1 өрхөөс гарах хог хаягдлын хэмжээг судлах ажлыг зохион байгуулан ажилласан.</p> <p>Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь</p>
52.	<p>АЗДҮА Х-ийн 1.1.2.2 дахь заалт</p> <p>СЗДҮАХ-ийн 3.1.9 дэх заалт</p>	<p>Гэр хорооллын усан сангуудыг шинэчлэх “Шинэ худаг” төслийг үргэлжлүүлэх, ус хадгалах савыг солих, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулах</p>	<p>Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 9.8 сая төгрөгийн санхүүжилтээр иргэн Б.Ганболдтой гэрээ байгуулан 4 худгийн ус хадгалах савыг солих, гадна талбайн тохижилтыг сайжруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
53.	<p>АЗДҮАХ-ийн 1.3.7 СЗДҮАХ-ийн 3.1.9</p>	<p>Сумын гүний худгийн тооллого хийх</p>	<p>Монгол Улсын усны тухай хуулийн 7.3-т заасны дагуу газрын гүний ус ашиглалт, хэрэглээнд тооллого зохион байгуулах ажилд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, Онги таац голын сав газартай хамтран ажлын хэсэг гарган тооллого зохион байгуулахад тус сумын хэмжээнд 21 гүний худаг, 3 цооног 1 гар худаг тоологдсон. Тооллого хийх ажлыг жил болгоны 2 дугаар улиралд багтаан тоолж байхаар шийдвэрлэсэн.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
<p><i>3.2 Дэд бүтэц, хот тохижилт, гэр хороолол: Хот байгуулалт, тохижилтын чанар стандартыг сайжруулж,ногоон хөгжлийн бодлогод суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлэх замаар иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ</i></p>			
54.	<p>АЗДҮАХ-ийн 2.2.5.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.3 дахь заалт</p>	<p>Хот доторх авто болон явган замуудыг нэмэгдүүлж, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах</p>	<p>2019 онд Авто замын сангийн 10 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 12.5 км зам шинээр тавигдсан байна.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
55.	<p>АЗДҮАХ-ийн 2.4-2.2.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.1.12 дахь заалт</p>	<p>Малчны хорооллын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх</p>	<p>Малчны хорооллыг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг аймгийн Засаг даргын 2019 оны А/337 дугаар захирамжаар эрх шилжүүлсний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хийж гүйцэтгүүлэн хүлээж авсан..</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
56.	<p>АЗДҮАХ-ийн 2.5-2.2.9 дэх заалт СЗДҮАХ-ийн 3.2.5 дахь заалт</p>	<p>Арвайхээр сумын гэр хорооллын цахилгаан хангамжийн</p>	<p>Дэлхийн банкны 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын хэмжээнд ашиглагдаж</p>

		өргөтгөлийг тогтмол хийх	буй 0.4 нам хүчдэлийн бүх сүлжээ кабелийг бүрэн шинэчилж, төмөр бетон тулгуур, ухаалаг тоолууртай болгох бөгөөд зураг төсвийн ажлын гүйцэтгэгч шалгарч ажлын зураг хийгдэж байна. Тодорхой үр дүнд хүрсэн- 70 хувь
57.	АЗДҮАХ-ийн 2.5, 2.2.12 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.4 дэх заалт	Арвайхээр сумын гэрэлтүүлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн 320 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 багийн нутаг дэвсгэрт 120 ширхэг цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй-100 хувь
58.	АЗДҮАХ-ийн 2.5, 2.2.5 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.9 дэх заалт	Нийтийн болон амины орон сууцны хороолол, хотхон байгуулж, ахмадын болон залуусын түрээсийн орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Энэ онд шинээр хийгдэж буй хаус хороолол нь Таун хаус 68ш, "А" амины сууц 32ш, "В" амины сууц 41ш, "С" амины сууц 21ш, "D" амины сууц 20ш, нийт 182 ш амины орон сууц баригдах бөгөөд инженерийн шугам сүлжээ, цахилгаан эрчим хүч татах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. Үр дүнтэй-100 хувь
59.	АЗДҮАХ-ийн 2.5-2.1.2 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.1 дэх заалт	ЕБ-ын 4-р сургууль, Багийн нэгдсэн төв, 7-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, 3-р цэцэрлэг, Ганданпунцоглин хийдийн гадна авто зогсоол хийгдэх	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд улсын төсвийн 900 сая төгрөгөөр 16 байршилд 20000 м ² авто зогсоол хийхээр төлөвлөгдөж зогсоолын газруудыг тэгшлэх ажлууд бүрэн хийгдэж дууссан. Үр дүнтэй 100 хувь
60.	АЗДҮАХ-ийн 2.5-2.2.6 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.17 дахь заалт	Хуучин орон сууцнуудын нийтийн эзэмшлийн хэсэг, барилгын гадна фасад, дээвэр, орцыг шинэчлэн засварлаж, орчны тохижилт хийх	Энэ онд 108, 454, 455 дугаар байрны гадна фасадыг шинэчлэх ажлыг Хүүшийн гэгээ ХХК орон нутгийн төсвийн 120 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Мөн 48 айлын сууцы дээврийн засварын ажлыг 17 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Монголиан мистери ХХК хийж гүйцэтгэсэн. Үр дүнтэй -100 хувь
61.	АЗДҮАХ-ийн 3.3.4.3 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.1.3 дахь заалт	Баг тус бүрт иргэдийн амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 49.5 сая төгрөгийн санхүүжилтээр 1,10 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай барих ажлыг гүйцэтгүүлэн ашиглалтад оруулсан.

			Үр дүнтэй 100 хувь
62.	АЗДҮАХ-ийн 2.5, 2.4 дэх заалт СЗДҮАХ-ийн 3.1.3 дахь заалт	Баг тус бүрд гэр хорооллын стандартын дагуу тохижуулсан жишиг өрх, жишиг гудамж бий болгох	Гэр хорооллын стандартын дагуу хашаа хороо гудамжаа тохижуулах сургалт мэдээллийг жил бүр багийн ажлын албатай хамтран зохион байгуулдаг ба 2019 онд “Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд 22 шилдэг тохижилттой өрх, Их-Уул Ягаан толгойн 6-р багийн 4 дүгээр гудамж, Өлзийтийн 4 дүгээр багийн 17 дугаар гудамж, Рашаантын 8 дугаар багийн 40,41 дүгээр гудамжны иргэд тус тус хашаа хороогоо тохижуулж, жишиг тохижилттой өрх гудамж болсон байна. Үр дүнтэй 100 хувь
63.	АЗДҮАХ-ийн 2.5, 2.6 дахь заалт СЗДҮАХ-ийн 3.2.1 дэх заалт	Нийтийн тээврийн автобусны буудлын тоог нэмэгдүүлэх	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 66 сая төгрөгийн санхүүжилтээр 1, 9, 5, 10, 11, 13 дугаар багуудад орчин үеийн стандартад нийцэхүйц лед гэрэл, камержуулалт бүхий нийтийн тээврийн 22 зогсоолыг Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГ-азар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй-100 хувь
Салбарын дундаж 94,7 хувь			
4. Төсөв санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалт			
<i>4.1 Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлого зохицуулалт: Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуйг дэмжин, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх замаар сумын эдийн засгийн өсөлтийг хангана</i>			
64.	СЗДҮАХ-ийн 4.1.1 дэх заалт	Сумын жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдийн судалгаа гаргаж, нэгдсэн судалгааны сан бүрдүүлэн сумын эдийн засгийг хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон батлуулах,	Сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дэлгэрэнгүй судалгааг 13 багаас авч нэгтгэхэд сумын дүнгээр нийт 861 иргэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд салбараар авч үзвэл, арьс ширэн эдлэл 1.6 хувь, ноосон эдлэл үйлдвэрлэл 1.3 хувь, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.3 хувь, барилгын материалын үйлдвэрлэл 1.9 хувь, мод модон эдлэлийн үйлдвэрлэл 6.7 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 1.8 хувь, хүнсний үйлдвэрлэл 3.7 хувийг тус тус эзэлж байна. Тус сумын хэмжээнд оёмол бүтээгдэхүүн, модон эдлэл, хүнсний үйлдвэрлэл нийт үйлдвэр үйлчилгээний 17.7 хувийг эзэлж байгаа нь ЖДҮ-ийн тэргүүлэх чиглэлд орохоор харагдаж байна. Үр дүнтэй 100 хувь

65.	СЗДҮАХ-ийн 4.1.3 дахь заалт	СХСангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулах, программд шивж оруулах	Зээлийн эргэн төлөлт 2019 оны 1-10 сард нийт 182.5 сая төгрөг төлөгдсөн байна. 2018 оны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 345.1 сая төгрөгөөс 17.0 хувь буюу 58.6 сая төгрөг төлөгдсөн байна. Зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах чиглэлээр бүх зээлдэгч нартай утсаар холбогдож Зээлийн нэгдсэн программ, Монгол банкны мэдээллийн сангийн талаар мэдээлэл өгч, 2 удаа албан мэдэгдэл хүргүүлж ажиллалаа. 2019 оны 11 дугаар сарын 30-ны байдлаар зээлдэгч нарын мэдээлэл, эргэн төлөлтийн байдлыг 93.5 хувьтай оруулаад байна. Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь																																																
66.	АЗДҮАХ-ийн 2.1, 6.4, СЗДҮАХ-ийн 4.1.4 дэх заалт	Сумын татварын болон татварын бус орлогыг нэр төрлөөр сар бүр жигд төвлөрүүлэх, урьд оноос нэмэгдүүлэх	2018 онд сумын төсвийн орлогод 1134.3 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан бол 2019 онд 35.0 хувиар нэмэгдүүлэн 1531.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталсан ба сар улирлын хуваарийн дагуу биелэлтийг тооцож байна. Сумын төсвийн татварын орлого сар бүр жигд биелж ирсэн. 2019 оны 1-11 сарын биелэлт: Өссөн дүнгээр <table border="1" data-bbox="1288 798 2128 1197"> <thead> <tr> <th></th> <th>Баталсан</th> <th>Гүйцэтгэл</th> <th>биелэлт, хувиар</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1 дүгээр сар</td><td>87828.8</td><td>195606.8</td><td>222.7</td></tr> <tr><td>2 дугаар сар</td><td>195624.8</td><td>352025.1</td><td>179.9</td></tr> <tr><td>3 дугаар сар</td><td>308820.9</td><td>472673.3</td><td>153.0</td></tr> <tr><td>4 дүгээр сар</td><td>417257.0</td><td>605392.2</td><td>45.1</td></tr> <tr><td>5 дугаар сар</td><td>557190.9</td><td>775037.5</td><td>139.1</td></tr> <tr><td>6 дугаар сар</td><td>88184.8</td><td>868722.2</td><td>126.2</td></tr> <tr><td>7 дугаар сар</td><td>94778.8</td><td>1081070.9</td><td>136.0</td></tr> <tr><td>8 дугаар сар</td><td>908626.6</td><td>1202555.4</td><td>132.3</td></tr> <tr><td>9 дүгээр сар</td><td>039448.1</td><td>1 346555.3</td><td>129.5</td></tr> <tr><td>10 дугаар сар</td><td>1182079.6</td><td>1484121.3</td><td>125.6</td></tr> <tr><td>11 дүгээр сар</td><td>334344.4</td><td>1623843.6</td><td>121.7</td></tr> </tbody> </table> Үр дүнтэй 100 хувь		Баталсан	Гүйцэтгэл	биелэлт, хувиар	1 дүгээр сар	87828.8	195606.8	222.7	2 дугаар сар	195624.8	352025.1	179.9	3 дугаар сар	308820.9	472673.3	153.0	4 дүгээр сар	417257.0	605392.2	45.1	5 дугаар сар	557190.9	775037.5	139.1	6 дугаар сар	88184.8	868722.2	126.2	7 дугаар сар	94778.8	1081070.9	136.0	8 дугаар сар	908626.6	1202555.4	132.3	9 дүгээр сар	039448.1	1 346555.3	129.5	10 дугаар сар	1182079.6	1484121.3	125.6	11 дүгээр сар	334344.4	1623843.6	121.7
	Баталсан	Гүйцэтгэл	биелэлт, хувиар																																																
1 дүгээр сар	87828.8	195606.8	222.7																																																
2 дугаар сар	195624.8	352025.1	179.9																																																
3 дугаар сар	308820.9	472673.3	153.0																																																
4 дүгээр сар	417257.0	605392.2	45.1																																																
5 дугаар сар	557190.9	775037.5	139.1																																																
6 дугаар сар	88184.8	868722.2	126.2																																																
7 дугаар сар	94778.8	1081070.9	136.0																																																
8 дугаар сар	908626.6	1202555.4	132.3																																																
9 дүгээр сар	039448.1	1 346555.3	129.5																																																
10 дугаар сар	1182079.6	1484121.3	125.6																																																
11 дүгээр сар	334344.4	1623843.6	121.7																																																
67.	АЗДҮАХийн 2.1.5.1, СЗДҮАХ-ийн 4.1.5 дахь заалт	Төсвийг үр ашигтай зарцуулан хариуцлага сахилгыг дээшлүүлэх	Төсөвт байгууллагын төсвийг сар бүрийн батлагдсан төсвийн дагуу зарцуулж байна. 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийж, ололт, дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар төсөв захирагч нягтлан бодогч нарыг хамруулан сургалт, семинар																																																

		<p>зохион байгуулсан. 2018 оны төсөв, санхүүгийн үзүүлэлтээр байгууллагын төсөв шууд захирагч, нягтлан бодогч нарын ажлыг дүгнэн сумын Засаг даргын захирамжаар батлагдсан журмын дагуу урамшуулал олгосон. Мөн ЕБ-н 4 дүгээр сургууль, 3 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч нарт хариуцлага тооцсон байна.</p> <p>2019 оны 11 дүгээр сарын байдлаар сумын дүнгээр төсвийн зарлагын гүйцэтгэлийг харуулбал:</p> <table border="1" data-bbox="1279 427 2119 580"> <thead> <tr> <th></th> <th>Батлагдсан</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хэмнэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ОНБайгууллагууд</td> <td>1952987.8</td> <td>1865411.6</td> <td>87576.2</td> </tr> <tr> <td>ТЗШ-ийн байгууллагууд</td> <td>2587138.4</td> <td>11650281.5</td> <td>936856.9</td> </tr> <tr> <td>Сумын дүн</td> <td>14540126.2</td> <td>3515693.</td> <td>11024433.1</td> </tr> <tr> <td colspan="4" style="text-align: center;">Үр дүнтэй 100 хувь</td> </tr> </tbody> </table>		Батлагдсан	Гүйцэтгэл	Хэмнэлт	ОНБайгууллагууд	1952987.8	1865411.6	87576.2	ТЗШ-ийн байгууллагууд	2587138.4	11650281.5	936856.9	Сумын дүн	14540126.2	3515693.	11024433.1	Үр дүнтэй 100 хувь				
	Батлагдсан	Гүйцэтгэл	Хэмнэлт																				
ОНБайгууллагууд	1952987.8	1865411.6	87576.2																				
ТЗШ-ийн байгууллагууд	2587138.4	11650281.5	936856.9																				
Сумын дүн	14540126.2	3515693.	11024433.1																				
Үр дүнтэй 100 хувь																							
	<p>Төсвийн ил тод байдлыг ханган Шилэн дансны мэдээллийг бүрэн, тогтмол байршуулж, нийтэд мэдээлэх</p>	<p>Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу сайт болон мэдээллийн самбарт байршуулан иргэдэд мэдээлж байна. Сумын Санхүүгийн албанаас “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийг улирал тутам шалгаж, дүнг байгууллагын дарга эрхлэгч нарт танилцуулан заавар зөвлөмж өгөн ажиллаж байгаа боловч 2019 оны 3-р улирлын байдлаар өмнөх хугацааны үр дүнгээс буурсан байна. Нийт хугацаа хоцорсон мэдээллийн 64.9 хувийн ӨЭМТөвүүд эзэлж байна. Мэдээллийн давтамжийг өмнөх онтой харьцуулахад:</p> <table border="1" data-bbox="1279 922 2119 1193"> <thead> <tr> <th></th> <th>2018 оны 3-р улирал</th> <th>2019 оны 3-р улирал</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Мэдээлэх</td> <td>2554</td> <td>2766</td> </tr> <tr> <td>Мэдээлсэн /хугацаандаа/</td> <td>2440</td> <td>2572</td> </tr> <tr> <td>/хожимдуулсан/</td> <td>114</td> <td>194</td> </tr> <tr> <td>Мэдээлээгүй</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хэрэгжилтийн хувь</td> <td>95.5</td> <td>93.0</td> </tr> <tr> <td colspan="3" style="text-align: center;">Үр дүнтэй 100 хувь</td> </tr> </tbody> </table>		2018 оны 3-р улирал	2019 оны 3-р улирал	Мэдээлэх	2554	2766	Мэдээлсэн /хугацаандаа/	2440	2572	/хожимдуулсан/	114	194	Мэдээлээгүй			Хэрэгжилтийн хувь	95.5	93.0	Үр дүнтэй 100 хувь		
	2018 оны 3-р улирал	2019 оны 3-р улирал																					
Мэдээлэх	2554	2766																					
Мэдээлсэн /хугацаандаа/	2440	2572																					
/хожимдуулсан/	114	194																					
Мэдээлээгүй																							
Хэрэгжилтийн хувь	95.5	93.0																					
Үр дүнтэй 100 хувь																							
68.	<p>АЗДҮАХ-ийн 2,1,3,1 СЗДҮАХ-ийн 4.1.6</p>	<p>Аймгийн татварын хэлтэс, ЭБЦТС-тай төсвийн орлого бүрдүүлэх талаар хамтран ажиллах, гэрээ байгуулах, дүгнэх</p>	<p>Аймгийн Татварын хэлтэстэй 2018 онд байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэн давсан орлогын 10 хувиар тооцож, 1469.9 мянган төгрөгийн урамшууллыг сургалтын тоног төхөөрөмж авахад зориулан олгосон. 2019 онд гурвалсан гэрээг байгуулан сар бүр биелэлтийг тооцож байна.</p> <p style="text-align: center;">Үр дүнтэй 100 хувь</p>																				

Салбарын дундаж 95хувь		
5. Нутгийн удирдлага, эрх зүйн бодлого зохицуулалт		
<i>5.1 Төрийн алба, эрх зүйн шинэчлэл: Иргэдийн оролцоо, хяналтад суурилсан, ёс зүйтэй, мэргэшсэн, чадварлаг нутгийн захиргааны байгууллагыг бэхжүүлж, хууль тогтоомж иргэн бүрт эрх, тэгш, шударга үйлчлэх зарчмыг баримтална.</i>		
69.	АЗДҮАХ-ийн 4.1.2.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.2 дахь зорилт	ОНЗЗны байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад ажилчдын амралт, фитнесийн өрөөг тохижуулах
		Аймгийн Засаг даргын 2012.03.27-ны өдрийн а/113 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд тус сумын Засаг даргын Тамгын газрын нэг давхрын заалыг албан хаагчдын амралт, спорт, чийрэгжүүлэлтийн зориулалтаар тохижуулсан. Үр дүнтэй 100 хувь
70.	АЗДҮАХ-ийн 4.1.7.1 дэх зорилт СЗДҮАХ-ийн 5.1.3 дахь зорилт	ОНЗЗ-ны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг хөндлөнгийн байгууллага болон иргэд, үйлчлүүлэгчдээр үнэлүүлэх, үр дүнг тооцох.
		Хэрэглэгчийн үнэлгээг улирал тутамд авах тухай үр дүнгийн гэрээнд заасан байдаг. Үүний дагуу 2019 онд хэрэглэгчийн үнэлгээг ТҮНТөв, ОНЗЗБайгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдлэг ур чадвар, ажлын туршлага, цаг ашиглалтын талаар нийт 5 удаа 260 гаруй иргэнээс хэрэглэгчийн үнэлгээг авч дүнг нэгтгэн танилцуулж, үнэлгээнээс гарсан санал хүсэлт, гомдол, дэвшилттэй санааг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Үнэлгээг доорх ерөнхий агуулгад багтаан авсан байдаг. Үүнд: Иргэдтэй шударга ил тод ажиллаж байгаа тухайд 82 % нь маш сайн үнэлсэн байдаг. Иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ анхаарах асуудал гэсэнд дийлэнх нь илүү түргэн шуурхай байх, Аль үйлчилгээ илүү чирэгдүүлж буйд: иргэний бүртгэл, банк, эрчим, халамж гэсэн үйлчилгээ дийлэнх байсан Ажилчдын цаг ашиглалт маш сайн гэж 85 % нь үзсэн. Ерөнхий төлөв эерэг буюу сайн дүгнэсэн байсан. Үр дүнтэй 100 хувь
71.	АЗДҮАХ-ийн 4.1.8.2 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.6 дахь зорилт	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэсгийн ахлагч нартай хамтран ажиллах, ажлын үр дүнд үндэслэн урамшууллын тогтолцоог бий болгох.
		Хэсгийн ахлагч нартай хамтран ажиллах гэрээний дагуу 11,5 сая төгрөгийг төсөвт суулган сар бүр 5000 төгрөгийн урамшуулал олгогдоод явж байна. Цаашид 195 хөршийн холбоог байгуулж ахлагч нарыг томилон гэрээ байгуулж сарын урамшууллыг нэмэгдүүлэн ажиллахаар гэрээ байгуулсан.

			Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь
72.	АЗДҮАХ-ийн 4.1.11.2 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.9 дахь зорилт	"Багийн нэгдсэн өдөрлөг" болон "Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг уламжлал болгон зохион байгуулах.	Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Арвайхээр сумын багуудын нэгдсэн өдөрлөгийг 9 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Өдөрлөгийн арга хэмжээнд 13 баг тус бүр гэр барьж багийн иргэдээ хүлээн авсан. Өдөрлөгийн арга хэмжээнд 1500 гаруй иргэн оролцсон. Арга хэмжээний үеэр төрөл бүрийн спортын тэмцээн уралдаан зохион байгуулж, шагнаж, урамшуулсан. Үүнд: Багийн мэндчилгээ /3 байр/ Буухиа /3 байр/ Олс таталт /3 байр/ Морьтой сайхан хос /3 байр/ Шагайн харваа /3 байр/ Мотоциклийн уран жолоодлого /3 байр/ Үндэсний бөхийн барилдаан / Түрүү, үзүүр, их шөвөг, шөвөг, 2 давсан/ Өдөрлөгийн зохион байгуулалтын зардалд нийт 12898300 төгрөг зарцуулсан. Үр дүнтэй 100 хувь
73.	АЗДҮАХ-ийн 4.3.2.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.16 дахь зорилт	Болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх	Болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх 12 800 000 төгрөгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлж зарцуулж дууссан. ОННөөц хөрөнгөөр урьд онд гарсан малын гоц халдварт шүлхий өвчний зардалд 28 000 000 төгрөгийн он дамжсан өглөг байсныг барагдуулсан. Нэмэгдүүлэх хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байгаа. Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь
74.	АЗДҮАХ-ийн 4.1.5.1 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.2 дахь зорилт	Төрийн албан хаагчдын "Сургалт-хөгжлийн хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлэх.	Аймгийн Засаг даргын 2017 оны А/255 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил хөтөлбөр"-ийн хүрээнд Төрийн албан хаагчдын дунд 3 зорилтын хүрээнд 16 удаагийн сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 416 албан хаагчийг хамруулан чадваржууллаа. Үүнээс төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан талаар товч

			<p>дурдвал: ЗДТГ-ын Төрийн захиргааны ажил хариуцсан мэргэжилтэн, Архив, бичиг хэргийн эрхлэгч, ХЗА-ны Дотоод ажил, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нарыг байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар сургалтын төлбөр /тус бүр 80000 төгрөг/-ийг гаргаж Архивын ерөнхий газрын 2019 оны Сургалтын төлөвлөгөөнд туссан “Баримт бичгийн стандарт, баримт бичгийн зохион бүрдүүлэх арга зүй” сэдэвт мэргэшүүлэх 3 өдрийн сургалтад, Төрийн захиргааны ажил хариуцсан мэргэжилтэнг “Удирдлагын академид 2019 онд улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөө”-ний 2.10-д заасан “Нутгийн захиргааны байгууллагын дотоод ажил, зохицуулалт” сэдэвт богино хугацааны 4 өдрийн сургалтад тус тус хамруулж томилолтын зардалыг холбогдох журмын дагуу олгосон.</p> <p>Мөн 13 багийн Хамтарсан гишүүд болох багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан 26 албан хаагчийг Дэлхийн Зөн ОУБ-тай хамтран Хэрэглээний Сэтгэл Судлалын Хүрээлэнгээс Улаанбаатар хотод зохион байгуулсан “Нийгмийн ажилтныг дахин мэргэшүүлэх” сэдэвт 3 өдрийн сургалтад хамруулж томилолтын зардлыг холбогдох журмын дагуу олгосон.</p> <p>Үр дүнтэй 100 хувь</p>
75.	СЗДҮАХ-ийн 5.1.17 дахь зорилт	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг шинэчилсэн хуулийн хүрээнд зохион байгуулах	<p>Тус сумын хэмжээнд 2019 оны цэргийн бүртгэлийг Цэргийн албаны тухай хууль, Батлан Хамгаалахын Сайдын 2017 оны А/331 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн бүртгэл явуулах журам”-ын дагуу 2019 оны 1 дүгээр сарын 04-11-ний өдрүүдэд Сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн а\320 дугаар захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах сумын комиссыг багийн Засаг дарга, Зохион байгуулагч нарыг оролцуулан 33 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан.Цэргийн бүртгэлд 7644 иргэн хамрагдахаас 6423 иргэн биеэр, 543 цэрэгжсэн 6966 иргэн буюу 91.2 хувьтай хамрагдлаа.</p>

			<p>Нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний байлдагч, түрүүч 2208 иргэний ЦМД /цэргийн мэргэжлийн дугаар/-ыг шинэчилсэн. Цэргийн бүртгэлийн үеэр ЦҮҮ /цэргийн үүрэгтний үнэмлэх/ шинээр авах болон үрэгдүүлсэн 450 иргэнд ЦҮҮ бичилт хийж олгосон. Тоо бүртгэлийн үеэр тоо иргэдэд "Цэргийн албаны тухай" хууль, "Зөрчлийн тухай" хуулиудыг таниулан сурталчлах арга хэмжээг сумын тоо бүртгэлийн комисс, багийн Засаг дарга нар хэрэгжүүлж ажилласан. 2019 оны Цэрийн бүртгэл явуулах тухай аймгийн Цэргийн штабаас ирүүлсэн чиглэлийн дагуу тоо бүртгэлийн материалыг 24 маягтаар үйлдэж хувийг Цэргийн штабт хүргүүлсэн. Аймгийн цэргийн штабаас ирүүлсэн чиглэлийн дагуу Арвайхээр сумын 2019 оны I ээлжийн цэрэг татлагыг 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар багуудын цэргийн насны залуучуудыг, II ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд 8, 9, 10, 11, 12, 13 дугаар багуудын цэргийн насны залуучуудыг хамруулан тус тус зохион байгуулсан. Нийт 1267 иргэнд цэргийн зарлан дуудах хуудас хүргүүлсэн. Зарлан дуудах хуудастай хамт Цэргийн албаны тухай, Зөрчлийн тухай хуулиудын холбогдох заалтыг хүргэж сурталчлан ажилласан. Цэрэг татлагын үзлэгээр 1267 иргэн хамрагдахаас 1248 буюу 98.5 хувьтай хамрагдсан. Хоёр ээлжийн цэрэг татлагаар нийт 67 иргэн Хилийн цэрэг болон Зэвсэгт хүчинд хуваарилагдан хяналтын тоог 100 хувь хангасан. Цэрэг татлагын комиссын үзлэгт зар аваад ирээгүй иргэдийг "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар аймгийн Цэргийн штабт нэрийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн.</p> <p style="text-align: right;">Үр дүнтэй 100 хувь</p>
76.	АЗДҮАХ-ийн 2.1.9.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.18 дахь зорилт	Гадаад харилцааг хөгжүүлэх, Дэд бүтцийн чиглэлээр тодорхой муж, улстай гэрээ байгуулан хамтран ажиллах	Аймгийн Засаг даргын дэргэдэх төсөл хөтөлбөрийн багтай хамтран БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймгийн Эзнээ хошуутай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, харилцаа тогтоох тохиролцоонд хүрсэн.

			Улмаар сумын ИТХурлын дарга бусад төлөөлөгчдийн хамт Эзнээ хошуунд зочилж, удирдлагуудтай санал солилцон хамтын ажиллагааны тохиролцоонд хүрсэн. Үр дүнтэй 100 хувь
77	АЗДҮАХ-ийн 2.1.9.3 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.18 дахь зорилт	БИНХурлыг цахимаар зохион байгуулах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх.	Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах зорилгоор багийн иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагааг цахимаар шууд дамжуулж, иргэдийн оролцоог ханган ажилласан. Цахим хурлын үйл ажиллагаатай нийтдээ 7200 орчим иргэн танилцсан байна. Цаашид цахим хурлын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байхаар төлөвлөн ажиллаж байна. БИНХурлыг цахимаар зохион байгуулах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд 1.0 сая төгрөгийн санхүүжилт зарцуулж, Соёмбо телевизтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь
78	АЗДҮАХ-ийн 4.1.5.2 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.1 дахь зорилт	Төрийн албан хаагчдын ажлыг үнэлэх үнэлгээний систем нэвтрүүлэх.	2020 оны төсөвт санхүүжилтийн эх үүсвэрийг суулгаж албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх "Статистик үнэлгээний нэгдсэн программ"-ыг нэвтрүүлэхээр болсон. Үнэлэх боломжгүй
79	АЗДҮАХ-ийн 4.1.1.1 дахь зорилт СЗДҮАХ-ийн 5.1.1 дахь зорилт	Багийн нэгдсэн төвийн барилгыг камержуулах	Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар багийн нэгдсэн төв 2, 7, 3, 1, 9, 12 дугаар багийн төвүүдэд орчин үеийн IP/HD PTZ 2 mega pixel full HD-2.8-16 мм линзтэй 20 дахин томруулах хүчин чадал бүхий камер иж бүрнээр нь суурилуулж 30 хоногийг хугацаанд бичлэг хадгалах санах ой байрлуулсан. Уг хяналтын системийг байршуулснаар гар утас, таблет ашиглан бичлэг хийх, бичлэгийг ухрааж үзэх нөхцөл бүрэн хангагдсан. Үр дүнтэй 100 хувь
Салбарын дундаж 97 хувь			
Нийт дундаж 97,34 хувь			

5 зорилт 79 арга хэмжээ

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР